

ТӨСӨЛ

/ИНЕГ-ын Эдийн засгийн

зохицуулалтын хэлтсээс

боловсруулав. Утас: 28-2049,

Мэйл: [tsengelbayar@mcaa.gov.mn](mailto:tsengelbayar@mcaa.gov.mn) /**ИРГЭНИЙ НИСЭХИЙН ДҮРЭМ – 323****ТАРИФ**

БҮЛЭГ А. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ.....	2
323.1. Зорилго .....	2
323.3. Тодорхойлолт.....	2
БҮЛЭГ Б. ТАРИФ ТОГТООХ, ХЭРЭГЛЭХ .....	3
323.5. Олон улсын хуваарьт нислэгийн тарифыг тогтоох.....	3
323.7. Орон нутгийн хуваарьт нислэгийн тарифыг тогтоох .....	3
323.9 Захиалгат нислэгийн тариф тогтоох .....	4
323.11. Тарифын үндсэн баримт бичиг .....	4
323.13. Тарифын мөнгөн нэгж.....	4
323.15. Зорчигчийн тарифыг хэрэглэх .....	4
323.17. Дотоод зорчигчийн тариф .....	5
323.19. Тарифын хөнгөлөлт .....	5
323.21. Ачааны тарифыг хэрэглэх нь .....	5
323.23. Хураамж, татвар .....	5
323. 25. Буцаалт.....	6
323.27. Тээвэрлэгчийн үүрэг .....	6
БҮЛЭГ В. ТАРИФЫН МЭДЭЭЛЛИЙГ БҮРТГЭХ .....	6
323.29. Тарифын мэдээллийн бүртгэл .....	6
323.31. Тарифын тухай мэдээлэл .....	6
БҮЛЭГ Г. ТАРИФЫГ ОЛОН НИЙТЭД ТҮГЭЭХ .....	6
323.33. Тарифыг олон нийтэд түгээх.....	7
323.35. Тарифыг олон нийтэд нээлттэй байлгах .....	7
БҮЛЭГ Е. СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР .....	

## Бүлэг А. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

### ТАРИФ

#### **323.1 Зорилго**

Агаарын хөлгөөр зорчигч, тээш, ачаа, тээвэрлэх тарифыг баталгаажуулах /ИН-ийн тухай хуулийн 7.1.11/ тарифын өөрчлөлтийг агаарын тээврийн хэрэглэгчдэд мэдээлэх, тарифын үндэслэл болон мөрдөлтөнд хяналт тавихтай холбоотой харилцааг зохицуулахад энэ дүрмийн зорилго оршино.

Энэхүү дүрмээр иргэний агаарын тээврийн хуваарьт болон хуваарьт бус нислэгээр зорчигч, ачаа шуудан тээвэрлэх тарифыг тогтоох, мөрдөхөд тавигдах шаардлагуудыг тогтоож, олон улсын болон орон нутгийн зорчигч, ачаа, тээвэрлэхэд мөрдөж хэрэглэнэ.

Зорчигч болон тийз борлуулагч агентууд, агаарын тээвэр зуучийн байгууллагад мөн адил мөрдөгдөнө.

#### **323.3.Тодорхойлолт**

Энэхүү дүрэмд орсон нэр томъёог дараахь утгаар ойлгоно.

“Хууль” гэдэгт 1999 оны Иргэний Нисэхийн тухай Монгол Улсын хуулийг,

“*Тариф*” гэж агаарын тээвэрлэгчийн олон нийтэд зарласан, хянагдсан, үнэ, хураамж болон түүнтэй холбогдох Тээвэрлэлтийн нөхцлүүд;

“*Тийз* ” гэж агаарын тээвэрлэгч (эсвэл түүний нэрийн өмнөөс)-ийн олгосон “Зорчигчийн тийз ба Бүртгэгдсэн тээш” гэсэн нэртэй баримт бичиг эсвэл цахим тийзийг хэлэх бөгөөд түүний дотор

“*Олон улсын тариф*” нислэгийн зай, хугацаанаас хамаарч тогтоосон олон улсын зорчигч, ачаа, тээш тээвэрлэлтийн хөлсийг,

“*Мөрдөгдөх тариф*” зөвхөн тухайн агаарын тээвэрлэгчид хүчин төгөлдөр тарифыг;

“*Орон нутгийн тариф*” гэдэг нь орон нутгийн тухайн чиглэлд нэг зорчигчийг тээвэрлэх зардлыг багтаасан тарифыг.

*“зах зээл” гэдгийг энэ дүрмийн хувьд хоёр нисэх буудлын, эсвэл хотын хоорондхи агаарын тээврийн үйлчилгээний эрэлт хэрэгцээг*

*“Суудал захиалах” гэдэгт агаарын хөлөгт зорчигч тээвэрлэхээр тусгайлан үлдээсэн захиалсан суудлыг,*

*“Ердийн тариф” гэдэгт ямар нэгэн хязгаарлалтгүйгээр байгаа энгийн, бизнес, нэгдүгээр ангиллын тарифыг,*

*“Тарифын мэдээллийн сан” гэж тариф, тарифт орсон нэмэлт, буюу үлдээсэн тарифын анхны болон шинэчилсэн хуудас, мөн тарифт хийж буй оруулга, индекс болон баталсан тухай тэмдэглэлийг хэлнэ.*

*“Төлбөртэй тээш” гэдэгт Тээвэрлэгчийн тогтоосон үнэ төлбөргүй тээвэрлэх зорчигчийн ачааны хэмжээнээс илүү гарсан хэсгийг,*

*“Тусгай тариф” гэдэгт үндсэн тарифын нөхцлөөр тээвэрлэхийг хориглосон буюу тогтоосон тарифаас бусад бүх нэр төрлийн бараанд төлөх хэвлэн нийтлэгдсэн хөлсийг,*

*“Тээвэрлэгч” гэдэгт тээврийн гэрээний үндсэн дээр зорчигч, тээш, ачаа, шууданг агаараар тээвэрлэх зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллагыг,*

*“Тээвэрлэлтийн чиглэл” гэдэгт явах буудлаас очих буудал болон буцаж ирэх аялалыг,*

*“Хөнгөлөлт” гэдэгт тодорхой нөхцөлд тогтоосон тарифын түвшинг бууруулахыг,*

*“Дамжин өнгөрөх тийзний үнэ” гэдэг нь замын эхний цэгээс эцсийн цэг хүртэлх тийзний нийт үнэ юм. Энэ нь олон улсын болон орон нутгийн , хамтын буюу тус тусдаа тогтоогдсон тийзүүдийн нийлмэл тийз байж болно.*

*“Мөрдөгдөх тариф” зөвхөн тухайн тээвэрлэгч ашиглах тарифыг,*

*“Ачааны үнэ” гэдэгт гэрээ байгуулсны үндсэн дээр тээвэрлэлтэнд хүлээн авсан тухайн ачааны бодит үнийг,*

*“Ачааны тариф” гэдэгт агаарын хөлгөөр ачааг тээвэрлэхдээ нислэгийн зай, хугацаанаас хамаарч тогтоосон тээвэрлэлтийн хөлсийг,*

*“Варшавын Конвенц” гэдэгт Варшав хотноо 1929 оны 10 дугаар сарын 12-нд гарын үсэг зурсан олон улсын агаарын тээвэрт хамаарах зарим журмыг нэг мөр болгох тухай Конвенцийг нэмэлт өөрчлөлтийн хамт,*

## **Бүлэг Б.ТАРИФЫГ ТОГТООХ, ХЭРЭГЛЭХ**

### **323.5. Олон улсын хуваарьт нислэгийн тарифыг тогтоох**

Олон улсын хуваарьт нислэгийн тарифыг тухайн хоёр улсын хооронд тогтоосон Засгийн газар хоорондын хэлэлцээрээр өөрөөр заасан нөхцөл байдал үүсэхээс бусад тохиолдолд Олон улсын агаарын тээвэрлэгчдийн холбоо, ИАТА-ийн тарифын дүрмийн дагуу агаарын тээвэрлэгч өөрөө тогтооно.

### **323.7 Орон нутгийн хуваарьт нислэгийн тарифыг тогтоох**

1. Зорчигч болон ачаа тээвэрлэх хөлс, тарифын нөхцөлүүдийг тухайн тээвэрлэгч тал тогтоох бөгөөд Иргэний нисэхийн ерөнхий газар зөвхөн тарифын дээд хязгаарыг тогтооно.
2. Улсын төсөв болон тарифыг Иргэний нисэхийн ерөнхий газрын орлогоос нөхөн олговор авч үйлдэж байгаа нийгмийн үйлчилгээний агаарын тээврийн үйлчилгээний тарифыг ИНЕГ-аас тогтооно.

### **323.9. Захиалгат нислэгийн тариф тогтоох**

Захиалгат нислэгийн тарифыг тухайн тээвэрлэгч өөрөө тогтооно.

### **323.11. Тарифын үндсэн баримт бичиг**

Тарифын үндсэн баримт бичиг нь ИАТА-гийн тарифын тухай тогтоол, ИАТА Зорчигчийн тарифын ерөнхий дүрэм, ИАТА Ачааны тарифын ерөнхий дүрэм болон Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ Конвенциуд , Иргэний нисэхийн тухай хууль, Иргэний агаарын хөлгөөр тээвэр хийх дүрэм, тэдгээрт нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актуудаас бүрдэнэ.

### **323.13. Тарифын мөнгөн нэгж**

1.Тээвэрлэлт нь Монгол Улсаас эхлэлтэй бөгөөд Монгол Улсын нутаг дэвсгэрт борлуулж байгаа байгаа бүх тариф Монгол Улсын мөнгөн нэгжээр илэрхийлнэ. Энэ хэсгийн /б/-д зааснаас бусад тохиолдолд бүх ачаа, тийзний үнэ, төлбөрийг Монгол Улсын мөнгөн нэгж /төгрөг, мөнгө/-ээр бичнэ.

2.Нэг талаас Монголын Улсын цэгүүд, нөгөө талаас гадаад орны цэгүүдийн, эсвэл гадаад орнуудын цэгүүдийн хооронд хамаарах зорчигч, ачаа, тээшний үнэ төлбөрийг гадаад орны мөнгөн нэгжээр илэрхийлж болох ба үүнээс гадна энэ хэсгийн /а/ зүйлд заасны дагуу Монголын мөнгөн нэгжээр илэрхийлнэ. Гэхдээ:

а/Монголоос өөр улсын мөнгөөр илэрхийлэгдэж буй ачаа, тийзний үнэ, төлбөр нь тухайн ачаа, тийзний үнэ төлбөртэй үнэ цэнийн хувьд бодит эквивалент байна,

б/Ачаа, тийзний үнэ, төлбөрийг агуулж буй бүх хуудаст тухайн ачаа, тийзний үнэ, төлбөрийг илэрхийлсэн тухайн мөнгөн нэгжийг тодорхой заасан байна.

в/ Валют хөрвүүлэх ханшийг тээврийн бичиг баримт бүрдүүлэх өдрийн Монгол банкны ханшаар тогтооно

### **323.15. Зорчигчийн тарифыг хэрэглэх нь**

Нэг цэгээс нөгөө цэгийн хооронд зорчих зорчигчийн тариф нь мөнгөн дүнгээсээ хамааран хэд хэдэн янзаар тогтоож болох бөгөөд үүнийг тарифын ангилал буюу тарифын хэрэглээний нөхцөл гэнэ.

Тарифын хэрэглээний нөхцөл нь дотроо ашиглах нөхцлийн хязгаарлалтгүй тарифыг ердийн тариф гэж үзнэ.

Зорчигчийн тариф нь үйлчилгээний ангилал зэрэглэлээс хамаарч хуваагдана.

Ангилалд зэрэглэл тарифын түвшин хэрэглээний нөхцөлүүдээс шалтгаалан тариф нь өөр өөр түвшинд байж болно.

### **323.17. Дотоодын зорчигчийн тариф.**

Орон нутгийн зорчигчийн тарифыг монгол төгрөгөөр илэрхийлнэ.

Тээвэрлэгч нь агаарын тээврийн буюу түүнтэй холбоотой үйлчилгээ хийхдээ тухайн үед хүчин төгөлдөр мөрдөж буй төлбөрийн хэмжээнээс их буюу бага, эсвэл өөр төлбөрийг тогтоох, шаардах, хураах, авах ёсгүй.

Тээвэрлэгч нь зорчигчоос тухайн ангиллын тарифанд нисэх буудлын хураамж болон улсын татвар болон бусад дагалдах хураамжуудыг багтаасан эсэхээ зорчигчдод мэдээлнэ.

### **323.19. Тарифын хөнгөлөлт**

0-2 насны хүүхдийг тухайн тарифын үнийн дүнгийн 10 хүртэлх хувиар

12 хүртэлх насны хүүхдийг тухайн тарифын үнийн дүнгийн 50 хүртэлх хувиар тооцож хөнгөлнө.

Хөнгөлөлттэй тариф болон түүнийг хэрэглэх нөхцлийн талаар энэ Дүрэмд зааснаас өөрөөр хэрэглэх тохиолдолд ИНЕРөнхий газарт мэдэгдэнэ.

### **323.21. Ачааны тарифыг хэрэглэх нь**

Ачааны тариф нь зөвхөн тухай чиглэлийн нэг талын тарифаар тогтоогдоно.

Ачааны тарифыг тухай ачааны жин , эсвэл түүний эзлэх орон зай болон зорчигчдын тийзний ангилал, тарифын хувиар тогтооно.

Ачааны тарифыг ялгавартайгаар ангилж болно.

Үүнд:

- Агаарын хөлгийн төрлөөс
- Норм хэтэрсэн ачааны хүндийн жингээс
- Стандартын бус ачааны хэмжээнээс
- Нислэгийн маршрутаас
- Үйлчилгээний зэрэглэлээс

- Тухайн ачааны зэрэглэлээс тус тус хамааран ялгавартай тогтооно.

Нэмэлт төлбөрт ачааны төлбөрийг тусгай баримтанд бичигдэж тээвэрлэнэ.

### **323.23. Хураамж, татвар**

Тээвэрлэгч нь тээвэрлэлтийн тарифаас гадна тээвэрлэлт эхлэх замын, төгсгөлийн нисэх буудлуудад төлөх үйлчилгээний хураамж, улсын татварыг тээвэрлэлтийн бичиг баримтанд бичиж төлбөрийг авч болно.

### **323.25. Буцаалт**

Зорчигчийн тарифын төрөл, нөхцөл, хугацаанаас хамааран тийзний үнийн дүнгээс буцаан олголт хийнэ.

### **323.27. Тээвэрлэгчийн үүрэг**

а/ Тарифын тухай мэдээллийг олон нийтэд нээлттэй байлгана.

б/ Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тариф тогтоосон үндэслэл болох дараахь бичиг баримтуудыг ирүүлсэн байх шаардлагатай.

Үүнд:

- Тухайн нислэгийн чиглэлийн бизнес төлөвлөгөө
- Эдийн засгийн үр ашгийн тооцоо

в/ Тээвэрлэгч нь гадаад, дотоодын бусад агаарын тээвэрлэгч, үйлчилгээний байгууллага болон борлуулагч агент, тээвэр зуучлагчийн байгууллагатай тохирсон зорчигчийн, тээшний болон ачаа, шуудангийн тарифыг Иргэний нисэхийн ерөнхий газарт хүргүүлнэ.

г/ Тарифт өөрчлөлт оруулсан тохиолдолд хуанлийн 10 хоногийн дотор Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад мэдээлнэ.

## **БҮЛЭГ В . ТАРИФЫН МЭДЭЭЛЛИЙГ БҮРТГЭХ**

### **323.29. Тарифын мэдээллийн бүртгэл**

(а) Тарифын мэдээллийг Иргэний нисэхийн ерөнхий газар бүртгэж, тарифын мэдээллийн санд хадгалж, хөтөлнө.

(б) Тарифын тухай мэдээллийг 323.2(б), 323.15.(г)-д заасны дагуу бүртгэгдэж, хэвлэгдсэн тохиолдолд хүчин төгөлдөр гэж тооцно.

### **323.31. Тарифын тухай мэдээлэл**

(а) Тарифын мэдээлэлд:

Зорчигчийн тариф,

Тусгай зэрэглэлийн зорчигчдод үзүүлэх хөнгөлөлт,  
Тарифыг хэрэглэх нөхцөл, хугацаа,  
Үнэ төлбөргүй тээвэрлэх тээшийн хэмжээ,  
Төлбөртэй тээвэрлэх тээшний тариф,  
Ачааны тариф,  
Шилжүүлэх валютын ханш,  
Зорчигч тээвэрлэх үеийн хураамж,  
Шаардлагатай гэж үзсэн аливаа мэдээлэл хамаарна.

(б) Хөнгөлөлттэй тариф болон түүнийг хэрэглэх нөхцлийн талаар энэ дүрэмд зааснаас өөрөөр хэрэглэх тохиолдолд ИНЕГ-т мэдэгдэнэ.

## **БҮЛЭГ Г. ТАРИФЫГ ОЛОН НИЙТЭД ТҮГЭЭХ**

### ***323.33. Тарифыг олон нийтэд түгээх***

Тээвэрлэгчид тарифын мэдээллийг олон нийтэд дараахи хэлбэрээр мэдээлнэ.

(а) Нисэх онгоцны буудлууд дахь өөрийн борлуулалтын цэг, суудал захиалга борлуулалтын төв, төлөөлөгчийн газрууд, гэрээт борлуулагч агентууд болон борлуулалтын бусад агентуудад одоогийн мөрдөгдөж буй зорчигч, тээшний тариф болон тарифын нөхцлийг товхимол хэлбэрээр,

(б) Тарифын мэдээллийг цахим хэлбэрээр интернетэд байршуулах

### ***323.35. Тарифыг олон нийтэд нээлттэй байлгах***

(а) Тарифын мэдээллийг олон нийтэд хүртээмжтэй хэлбэрээр хадгална.

(б) Тээвэрлэгчийн ажилтнууд тарифын тухай мэдээлэл авахыг хүссэн хэн бүхэнд шаардлагатай мэдээллийг өгнө.

